



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

**МАНДАЛ СУМЫН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ЭЭЛЖИТ
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ
МОНГОЛ АРДЫН НАМД**

2024.08.07 № 17117-2024/13-УТА-НА-10

танай _____-ны № _____-т

**Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд
заасан шаардлагад нийцсэн талаарх дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4-т заасан төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны Мандал сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох Монгол Ардын намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Мандал сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар нь 2024 оны аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын

018020927

нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

Дүгнэлт

Монгол Ардын намын Мандал сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт арга, хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Мандал сумын Монгол Ардын намын мөрийн хөтөлбөр (.8. хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Мандал сумын Сонгуулийн хороонд

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН МАНДАЛ СУМЫН ИТХ-ЫН 2024 ОНЫ ЭЭЛЖИТ
СОНГУУЛЬД СЭЛЭНГЭ АЙМГИЙН МАНДАЛ СУМЫН МОНГОЛ АРДЫН
НАМЫН ХОРООНООС ДЭВШҮҮЛЖ БУИ**

МӨРИЙН ХӨТӨЛБӨР



МАНДАЛ СУМАА ХАМТДАА ХӨГЖҮҮЛБЭ

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийг чиглэл болгон Монгол Ардын Намаас УИХ-ын 2024 оны сонгуульд дэвшүүлсэн хөгжлийн зорилтуудыг орон нутагтаа хэрэгжүүлэх, Мандал сумынхаа хөгжлийг шинэ шатанд гаргах зорилгоор сум орон нутгийнхаа ард иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, төрийн бус байгууллагуудаас мөрийн хөтөлбөрт тусгуулахаар ирүүлсэн саналуудыг нягтлан үзэж, нэгтгэн дүгнэж, сумын нийгэм, эдийн засгийн хөгжлийн өнөөгийн байдалд тулгуурлан, Сэлэнгэ аймгийн Мандал сумын Монгол Ардын Намын Хорооноос 2024-2028 онд хийж хэрэгжүүлэхээр төлөвлөсөн мөрийн хөтөлбөрөө сонгогч олондоо өргөн барьж байна.


Үйл ажиллагааны үндсэн зорилтууд:

1. Нийгмийн хөгжил - Өв тэгш гэр бүл
2. Эдийн засгийн хөгжил – Хангалуун амьдрал
3. Дэд бүтцийн хөгжил – Шинэ хот
4. Ногоон хөгжил – Ээлтэй орчин
5. Засаглалын хөгжил –Цахим үйлчилгээ 5 бүлэг 111 багц арга хэмжээг хэрэгжүүлнэ.

НЭГ: НИЙГМИЙН ХӨГЖИЛ- ӨВ ТЭГШ ГЭР БҮЛ


1.1. ЭРҮҮЛ МЭНД - СПОРТ

- 1.1.1 Хүн амын дундаж насжилтыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд эрүүл мэндийн үзлэг, эрт илрүүлэг, үзлэг оношилгоог тасралтгүй үргэлжлүүлнэ.
- 1.1.2 Эрүүл мэндийн чиглэлээр хэрэгжүүлж байгаа төсөл хөтөлбөрүүдийг үргэлжлүүлж, чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- 1.1.3 Сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдэд эрүүл мэндийн үзлэгийг тогтмол зохион байгуулж, эрт илрүүлэх, эрүүлжүүлэх ажлыг чанаржуулна.
- 1.1.4 Эм, эмнэлгийн хэрэгслийн нийлүүлэлтийн чанар, аюулгүй байдалд тавих хяналтыг сайжруулна.
- 1.1.5 Эмч, эмнэлгийн ажилтнуудыг үе шаттайгаар гадаад, дотоодод туршлага судлах, давтан сургаж, мэргэшүүлж, мэдлэг, ур чадварыг нь дээшлүүлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулна.

- 
- 1.1.6 Орчин үеийн стандартын шаардлага хангасан өрхийн эмнэлэг шинээр барих асуудлыг холбогдох дээд шатны байгууллагад хүсэлт тавьж шийдвэрлүүлнэ.
- 1.1.7 Өрхийн эмнэлгүүдийг авто машинаар хангах асуудлыг үе шаттайгаар шийдвэрлэнэ.
- 1.1.8 Орчин үеийн стандартад нийцсэн хүүхдийн эмнэлэг барих асуудлыг дээд шатны байгууллагад уламжлан шийдвэрлүүлнэ.
- 1.1.9 Өрх, тосгоны эрүүл мэндийн төвд үзүүлэх эмнэлгийн анхан шатны тусламж, үйлчилгээнд шинэ дэвшилтэт арга технологийг нэвтрүүлэх, хурдавчилсан оношилгоо, өдрийн эмчилгээ, сэргээн засах, гэрээр үзүүлэх тусламжийн чанар хүртээмжийг дээшлүүлнэ.
- 1.1.10 Нэгдсэн эмнэлгийн, тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдал, хүртээмжийг нэмэгдүүлж орчин үеийн дэвшилтэт технологийг нэвтрүүлэх зорилгоор өвчтөнд ээлтэй аюулгүй дурангийн хагалгааг нэвтрүүлнэ.
- 1.1.11 Нийтийн биеийн тамирыг хөгжүүлэн, хүн амын бие бялдрыг чийрэгжүүлэх, сум орон нутгийнхаа нэрийг улс, аймаг, тив дэлхийд гаргаж буй тамирчдаа дэмжих зорилгоор “Спортлог мандалчууд” хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 1.1.12 Бүх нийтийн биеийн тамир спортыг хөгжүүлэх, түгээн дэлгэрүүлэх зорилгоор “Олон төрөлт спортын наадам”-ыг уламжлал болгон зохион байгуулна.
- 1.1.13 Бүх нийтийн биеийн тамир спортыг хөгжүүлэх зорилгоор орчин үеийн олон улсын стандартад нийцсэн хөл бөмбөгийн ногоон талбай байгуулна.
- 1.1.14 Баг бүрд 3х3 сагсан бөмбөгийн талбай барих ажлыг орон нутгийн төсвийн хөрөнгөөр үе шаттайгаар шийдвэрлэнэ.
- 1.1.15 Олон улсын стандартад нийцсэн Mandal-arena спорт цогцолбор барих санхүүжилтийг холбогдох байгууллагуудад уламжлан шийдвэрлүүлж, хэрэгжүүлнэ.
- 1.1.16 Залуучууд хөгжлийн төв шинээр барина.
- 1.1.17 Залуучуудын бие бялдрыг хөгжүүлэх фитнес төв байгуулах иргэдийн санал санаачилгыг дэмжиж, хамтран ажиллана.
- 1.1.18 УТБЗ-ын ХНН-ийн ажилтан албан хаагчдын спорт заал барих асуудлыг холбогдох байгууллагад уламжилж, шийдвэрлүүлнэ.

1.2. БОЛОВСРОЛ – СОЁЛ

- 1.2.1 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа ерөнхий боловсролын 3-р сургуулийн өргөтгөлийн барилгыг дуусгаж, ашиглалтад оруулна.
- 1.2.2 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа ерөнхий боловсролын 2-р сургуулийн барилгыг дуусгаж, ашиглалтад оруулна.
- 1.2.3 Мандал сумын ерөнхий боловсролын 5-р сургуулийн спорт заалыг зураг төсвийн дагуу барих ажлыг холбогдох байгууллагад уламжилж шийдвэрлүүлнэ.
- 1.2.4 “Чадварлаг багш” хөтөлбөрийг үргэлжлүүлж, элсэлтийн ерөнхий шалгалтад амжилттай оролцсон багш сурагчдыг урамшуулах шинэ тогтолцоог боловсруулан батлуулж, мөрдөж ажиллана.

- 
- 1.2.5 Мандал сумын эрэлт хэрэгцээнд шаардлагатай мэргэжилтэн бэлтгэх зорилгоор их, дээд сургуулийн салбар байгуулах саналыг холбогдох газарт уламжилна.
- 1.2.6 Үдийн цай хөтөлбөрийг хэрэгжүүлэх орчныг сайжруулах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.
- 1.2.7 Сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсролын сургуулийн гадна тоглоомын болон биеийн тамирын талбайг орчин үеийн стандарт шаардлагад нийцүүлэн тохижуулах ажлыг үргэлжлүүлнэ.
- 1.2.8 Зүүнхараа политехник коллежийг спорт заалтай болгох асуудлыг холбогдох байгууллагад уламжилж, шийдвэрлүүлнэ.
- 1.2.9 Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтыг нэмэгдүүлэх зорилгоор Мишээл, Мандал 3-р, Мандал 1-р цэцэрлэгийн өргөтгөлийн барилгыг шинээр барих санхүүжилтийг улсын төсөвт тусгуулж, хэрэгжүүлнэ.
- 1.2.10 Тарни 8-р багт төрийн үйлчилгээний цогцолбор байр санхүүжилтийг улс, орон нутгийн төсөвт тусгуулж, хэрэгжүүлнэ.
- 1.2.11 Орон нутаг судлах музей, номын сан бүхий “Хөгжлийн төв” барьж байгуулна.
- 1.2.12 Орчин үеийн стандарт шаардлагад нийцсэн кино театр барих хувийн хэвшлийг дэмжиж ажиллана.
- 1.2.13 Сургуулийн хүүхдийн автобустай болох асуудлыг дээд шатны байгууллагад хүсэлт тавьж шийдвэрлүүлнэ.
- 1.2.14 Үндэсний биет болон биет бус өвийг өвлүүлэх, түгээн дэлгэрүүлэх зорилгоор урлагийн их наадмыг жил бүр уламжлал болгон зохион байгуулна.

1.3 НИЙГМИЙН ХАЛАМЖ - ХАМГААЛАЛ

- 1.3.1 Ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж ажиллана.
- 1.3.2 “Энхмэнд сувилал” ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааг дэмжин ахмадын сувилалд ажиллах мэргэжилтэй боловсон хүчин, сувиллын орны тоог нэмэгдүүлж, тусламж үйлчилгээний нэр төрөл, чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- 1.3.3 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажиллах, зорчих нөхцөлийг хангасан стандартын барилга, зам, орчныг бий болгоно.
- 1.3.4 Хүчирхийлэл түүний даамжралаас сэргийлж, түр хамгаалах байрны үйл ажиллагааг дэмжин ажиллана.
- 1.3.5 Ажлын байрны стрессийг бууруулах, ажиллах эерэг орчин бүрдүүлэх, зөв зохистой харилцаа, хандлагыг төлөвшүүлэх зорилгоор сэтгэл зүйн зөвлөх үйлчилгээг нэвтрүүлнэ.
- 1.3.6 Хүүхэд харах үйлчилгээг дэмжиж ажиллана.
- 1.3.7 Хүүхдийг амьдрах ухаанд сургах зорилгоор хөдөлмөр зуслан, эмчилгээний зуслангийн үйлчилгээ явуулах хувийн хэвшлийг дэмжиж ажиллана.

ХОЁР: ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖИЛ – ХАНГАЛУУН АМЬДРАЛ

2.1 ХӨДӨӨ АЖ АХУЙ

- 2.1.1 Атрын 4-р аяны хүрээнд техникийн шинэчлэл хийх санал санаачилгыг дэмжиж, хөдөө аж ахуйн нэгдсэн парк байгуулах иргэдийн санал санаачилгыг дэмжинэ.
- 2.1.2 Газар тариалангийн эргэлтийн талбайн ашиглалтыг нэмэгдүүлж, үрийн шинэчлэл хийн, үр үйлдвэрлэлийг дагнан хөгжүүлэх ААН, иргэдийн санал санаачилгыг дэмжинэ.
- 2.1.3 Ээлжлэн тариалах технологийн дагуу ногоон тэжээл, таримал ургамлын тариалалтыг нэмэгдүүлэх чиглэлээр иргэд, аж ахуйн нэгж, байгууллагатай хамтран ажиллана.
- 2.1.4 Төмс, хүнсний ногоо тариалагчдыг дэмжин бүтээгдэхүүн борлуулалтын төвийг Улаанбаатар хотод бий болгоно.
- 2.1.5 Хүлэмжийн аж ахуйг нэг цэгт төвлөрүүлэн дэд бүтцийг шийдвэрлэж, гидропоник технологийг нэвтрүүлэх замаар смарт хүлэмж байгуулах ажлыг холбогдох дээд шатны байгууллагад уламжлан шийдвэрлүүлнэ.
- 2.1.6 Малын өтөг, бууц ашиглан бордоо үйлдвэрлэх иргэдийн санал санаачилгыг дэмжинэ.
- 2.1.7 Эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх, шилмэл омгийн малаар сүргийн бүтцийг сайжруулж, фермер байгуулах аж ахуйн нэгж, иргэнийг дэмжинэ.
- 2.1.8 “Шинэ хоршоо” хөдөлгөөний хүрээнд хоршоодыг хуулийн дагуу дэмжин ажиллана.
- 2.1.9 Мал, амьтны гоц халдварт өвчний голомт бүхий орон нутгаас ирэх малын хөдөлгөөнд цахим систем ашиглан хяналт тавих, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлнэ.
- 2.1.10 Сүүний чиглэлийн үхэр малладаг иргэдийг дэмжиж, малын үржил шим, ашиг шимийг нэмэгдүүлэх асуудлыг бодлогоор дэмжин ажиллана.
- 2.1.11 “Эрүүл мал” хөтөлбөр боловсруулж, хэрэгжилтэд нь хяналт тавин ажиллана.

2.2 ҮЙЛДВЭРЛЭЛ- ХУДАЛДАА

- 2.2.1 Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор “Мандалд үйлдвэрлэв” цэгүүдийг бусад аймаг, орон нутагт нээх ААН, иргэдийг дэмжиж ажиллана.
- 2.2.2 Гар урлалын бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа иргэд, аж ахуй нэгжид дэмжлэг үзүүлж, хамтран ажиллана.
- 2.2.3 Хүнсний ногооны савласан болон нөөшилсөн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжин ажиллана.
- 2.2.4 Үйлдвэрийн бүсийг шинээр байгуулж, иргэдийн амьдрах орчин нөхцөлд сөрөг нөлөө үзүүлж буй төмрийн үйлдвэрийг нүүлгэн шилжүүлэх асуудлыг холбогдох байгууллагад уламжилж шийдвэрлүүлнэ.
- 2.2.5 Бичил уурхайчдын олборлосон алтыг Монгол банканд тушаах нөхцөлийг бүрдүүлж, алтны худалдааны нэг цэгийн үйлчилгээг бий болгох, гарал үүслийг баталгаажуулах ажилд дэмжлэг үзүүлнэ.
- 2.2.6 Стандартад нийцсэн олон улсын худалдааны төв байгуулах санал санаачилгыг дэмжин ажиллана.

2.3 ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

- 2.3.1 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор ажлын байрны нээлттэй өдөрлөгийг зохион байгуулж, иргэдэд мэдээллийг түргэн шуурхай хүргэнэ.
- 2.3.2 Бичил уурхай эрхлэгчдийн үйл ажиллагааг хууль эрх зүйн хүрээнд дэмжин ажиллах цогц арга хэмжээг хэрэгжүүлнэ.
- 2.3.3 Бичил уурхай эрхлэгчдийг шинээр мэргэжил эзэмших, өөр ажлын байртай болоход дэмжлэг үзүүлнэ.
- 2.3.4 Орон нутагт баялаг бүтээгч иргэн, ААН-ийн бараа бүтээгдэхүүнийг төрийн худалдан авалтаар дэмжинэ.
- 2.3.5 Политехник коллеж төгссөн оюутан залуусыг ААН, байгууллагатай гэрээ байгуулан ажлын байраар хангах, орон нутагт шаардлагатай мэргэжилтэн бэлтгэх ангийг нэмж байгуулах талаар холбогдох байгууллагад уламжилна.
- 2.3.6 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж шинэ ажлын байр бий болгох зорилгоор төрөөс үзүүлж байгаа зээл тусламж, төсөл хөтөлбөрт хоршоо болон иргэдийг хамруулна.
- 2.3.7 Нутгийн иргэдийг түшиглэсэн аялал жуулчлалыг хөгжүүлэх үйл ажиллагааг дэмжин ажиллана.
- 2.3.8 Суманд шаардлагатай ажил мэргэжил, ажлын байрны судалгааг гаргаж, мэргэжлийн болон түр сургалтуудад хамруулна.


ГУРАВ: ДЭД БҮТЦИЙН ХӨГЖИЛ – ШИНЭ ХОТ

3.1 ХОТ ТӨЛӨВЛӨЛТ, ГАЗРЫН ХАРИЛЦАА

- 3.1.1 Хот байгуулалтын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, дахин төлөвлөлтийн төлөвлөгөө боловсруулна.
- 3.1.2 Сум, тосгонд байрлах ашиглалтын хугацаа дууссан төрийн болон нийтийн орон сууц, барилга байгууламжийн газрыг дахин төлөвлөлтөд оруулна.
- 3.1.3 Иргэнд шинээр өмчлүүлэх, эзэмшүүлэх газрын нөөцийг тогтоож, дэд бүтцийг бий болгон газраа эдийн засгийн эргэлтэд оруулах санал санаачилгыг дэмжинэ.
- 3.1.4 Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбай, орон сууц, гэр хорооллын камержуулалтыг нэмэгдүүлж, нэгдсэн удирдлага, хяналтын системд холбох ажлыг үргэлжлүүлнэ.
- 3.1.5 Гэр хорооллыг цэвэр ундны усаар хангах асуудлыг үе шаттайгаар шийдвэрлэж, 24 цагийн ажиллагаатай ухаалаг худгийг баг бүрд нэмж байгуулна.

3.2 ХОТ ТОХИЖИЛТ, ДЭД БҮТЭЦ

- 3.2.1. Гэр хорооллын шороон замыг асфальт болон бетон зам болгох асуудлыг үе шаттай хэрэгжүүлж, тэмдэг тэмдэглэгээг стандартын дагуу хийнэ.
- 3.2.2 Мандал сумаас Тарни 8-р баг хүртэлх авто замыг сайжруулах ажлыг үргэлжлүүлнэ.
- 3.2.3 Мандал сумаас Түнхэл тосгон чиглэлийн 45 км авто замыг сайжруулсан хайрган замтай болгох ажлыг үргэлжлүүлнэ.

- 
- 3.2.4 Түнхэл тосгоноос Батсүмбэр хүртэлх замыг асфальтан хучилттай болгох асуудлыг холбогдох дээд шатны байгууллагад уламжлан шийдвэрлүүлнэ.
- 3.2.5 Мандал сумын авто замын ачааллыг бууруулах зорилгоор сум доторх асфальтан замын хэмжээг нэмэгдүүлнэ.
- 3.2.6 Ерөнхий боловсролын 3, 4 дүгээр сургуулийн урд явган хүний гүүрэн гарц барина.
- 3.2.7 Төмөр замын араас урагш гарах нүхэн гарц шинээр барих зөвшөөрлийн асуудлыг холбогдох байгууллагад уламжлан шийдвэрлүүлж, авто машины нүхэн гарцын байгууламжийг ашиглалтад оруулна.
- 3.2.8 Үерийн далангийн техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулж, шинээр барьж, ашиглалтад оруулна.
- 3.2.9 Мандал сумын төвд 50 мвт-ийн дулааны цахилгааны станц барих асуудлыг төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээгээр шийдвэрлэнэ.
- 3.2.10 Сумын төвийн инженерийн шугам сүлжээг нэмэгдүүлэн айл өрх, аж ахуйн нэгж байгууллагуудыг бохирын шугамд холбох ажлыг үргэлжлүүлнэ.
- 3.2.11 Сумын төвийн цэвэрлэх байгууламжийн үйл ажиллагааг өргөтгөх, хүчин чадлыг нэмэгдүүлнэ.
- 3.2.12 Сум, тосгодын нийтийн эзэмшлийн гудамж талбайн гэрэлтүүлгийн ажлыг үргэлжлүүлэн хийж, хөндлөн гудмуудыг гэрэлтүүлэгтэй болгоно.
- 3.2.13 Гэр хорооллын айл өрхүүдийг гуравласан сүлжээнд (*интернэт, утас, телевиз*) холбох ажлыг үргэлжлүүлнэ.
- 3.2.14 Орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудын эдийн засгийн үр өгөөжийг дээшлүүлэх бодлогын хүрээнд орон сууц нийтийн аж ахуйн төв байгуулж, СӨХ-ийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ.
- 3.2.15 Шинэ суурьшлын бүсүүдийн цахилгааны шугам сүлжээг нэмэгдүүлэх ажлыг үргэлжлүүлэн хийнэ.
- 3.2.16 Хүүхдийн парк барих төсөв, тооцоог хийж, холбогдох дээд шатны байгууллагад уламжилж, шийдвэрлүүлнэ.
- 3.2.17 Баг бүрд ахуйн үйлчилгээний төв шинээр барина.
- 3.2.18 Хот хоорондын тээвэр болон сум доторх авто болон нийтийн тээврийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор авто вокзал шинээр байгуулах асуудлыг холбогдох байгууллагуудтай хамтран шийдвэрлэнэ.
- 3.2.19. Төмөр замчдын 1-р багт байрлах 96 айл, 36, 43, 45, 47-р байр, спиртийн 300 айлын орон сууц, төмөр замын 41, 46, 40, 44-р байр, Тост өргөө 100 айлын орон сууц, Хатант, Цагдаагийн 25 айлын орон сууцуудын гадна фасадыг үе шаттайгаар засварлах асуудлыг холбогдох байгууллагын дэмжлэгтэйгээр шийдвэрлэнэ.
- 3.2.20 “1000 айлын орон сууц” шинээр барих ажлыг хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагуудын дэмжлэгтэйгээр хэрэгжүүлнэ.
- 3.2.21 Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд эмч, багш, цагдаа, онцгой байдлын албан хаагчдыг орон сууцанд хамруулах асуудлыг үе шаттайгаар шийдвэрлэнэ.
- 3.2.22 Гэр хорооллын гудамж талбайн зам талбайг засварлах нэгж байгуулах асуудлыг ОНӨААТҮГ-дад түшиглэн байгуулж, холбогдох техник тоног

төхөөрөмжөөр хангах асуудлыг дээд шатны байгууллагад уламжлан шийдвэрлэнэ.



ДӨРӨВ: НОГООН ХӨГЖИЛ – ЭЭЛТЭЙ ОРЧИН

4.1 БАЙГАЛЬ ОРЧИН

- 4.1.1 Тэрбум мод үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлж, зорилгоор “Ногоон сум” хөдөлгөөнийг өрнүүлнэ .
- 4.1.2 Утаагүй түлшний цех байгуулах иргэдийн санал санаачилгыг дэмжиж агаарын бохирдлыг бууруулна.
- 4.1.3 Мандал сумын иргэдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор “Мандал цэцэрлэгт хүрээлэн” байгуулах асуудлыг шийдвэрлэнэ.
- 4.1.4 Мод, модон бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн парк байгуулах иргэдийн санаачилгыг дэмжиж ажиллана.

4.2 ХОГ ХАЯГДАЛ, АГААР, ХӨРСНИЙ БОХИРДОЛ

- 4.2.1 Сумын нэгдсэн хогийн цэгийг нүүлгэн шилжүүлж, шинэ бүсэд стандартын дагуу шинэ хогийн цэг нээнэ.
- 4.2.2 Агаар, хөрсний бохирдлыг бууруулах, яндангийн тоог цөөлөх цогц арга хэмжээг мэргэжлийн байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ .
- 4.2.3 Хог хаягдлыг ангилан ялгах дадал хэвшлийг бий болгох, иргэдийн бүлгийн үйл ажиллагааг дэмжиж сумын хэмжээнд гялгарт уутны хэрэглээг багасгах бодлого баримтална.
- 4.2.4 Хөрсний бохирдлоос сэргийлж, амралт сувиллын газруудыг боловсон ариун цэврийн байгууламжтай болгоход хяналт тавьж, шийдвэрлэнэ.
- 4.2.5 Айл өрх бүр хөрсөнд үл нэвчих стандарт шаардлага хангасан бие засах газартай болох асуудлыг уриалж, иргэдийн бүлгийг дэмжиж ажиллана.

4.3 АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ

- 4.3.1 Аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг иргэн, ААН, байгууллагын үйл ажиллагааг дэмжиж сумын байгалийн үзэсгэлэнт болон түүхэн дурсгалт газруудыг судлан аялал жуулчлалын бодлогыг хэрэгжүүлнэ.
- 4.3.2 Сумын хэмжээний аялал жуулчлалын бүсүүдийг шинээр тогтоож, иргэд, аж ахуйн нэгж албан байгууллагуудын үйл ажиллагааг дэмжиж ажиллана.
- 4.3.3 Аялал жуулчлалыг дэмжих бодлогын хүрээнд үйлдвэрлэл үйлчилгээний байгууллагуудыг дэмжиж ажиллана.

ТАВ: ЗАСАГЛАЛЫН ХӨГЖИЛ – ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭ

5.1 НУТГИЙН УДИРДЛАГА

- 5.1.1 Төрийн байгууллагад хандсан иргэдийн өргөдөл, хүсэлтийг шуурхай шийдэж, тушаал шийдвэр, үүрэг даалгаврын биелэлтийг цахим хэлбэрээр хянадаг болно.
- 5.1.2 Төрийн үйлчилгээг түргэн шуурхай, хүртээмжтэй хүргэх зорилгоор хэсгийн ахлагч нарын үйл ажиллагааг идэвхжүүлэн ажиллана.
- 5.1.3 Гэр хороолол, гудамжны хаягжилтыг шинэчлэн, хаягийн давхцалыг арилгана.

5.2. ГАДААД ХАРИЛЦАА ХАМТЫН АЖИЛЛАГАА

- 5.2.1 Найрамдалт харилцаатай Бүгд найрамдах Солонгос улсын Ы-сон сумтай хамтын ажиллагаагаа өргөжүүлж, мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх, давтан сургах чиглэлээр хамтран ажиллана.
- 5.2.2 Бүгд найрамдах Солонгос улсын Үжинбү хотын Шинхан их сургуультай хамтын ажиллагаагаа өргөжүүлж оюутан элсүүлэх, багш сурагч солилцоо арга хэмжээг үргэлжлүүлнэ.
- 5.2.3 Бүсчилсэн хөгжлийн бодлогын хүрээнд хөрш зэргэлдээ аймаг, сумдтай хамтын ажиллагаа тогтоон хамтарч ажиллана.
- 5.2.4 Сэлэнгэ аймаг Япон улсын Шизоуки мужийн хамтын ажиллагааны хүрээнд хүлэмжийн аж ахуй эрхлэх гэрээт ажилтан бэлтгэх, мэргэжлийн сургалтад хамруулах асуудлыг үе шаттайгаар шийдвэрлэнэ.